БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.БОЛДБААТАР
20.....он ..09.. сар ..15.. өдөр

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН БАЯНБУЛАГ 1-Р БАГТ БУЛГЫН ЭХ ХАШИХ АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 09-р сарын 15-ны өдөр Дугаар 2025/03 Баянмөнх сум

1	Үндэслэл	✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19,2,6 дахь заалт ✓ Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам” ✓ Аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, ✓ Сумын Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
2	Баримт бичгийн үе шат	Булгын эх хаших үйл ажиллагааг эхлүүлэхдээ дараах үе шатны дараалаар хийнэ. Үүнд: А. Газар дээр нь ирж газрын байршил онцлогтай танилцах Б. Байгаль орчны судалгаа, хүрээлэн буй орчныг ажиглах В. Ажил гүйцэтгэлийн дараах баримт бичиг /ажил хүлээлцэх акт, санхүүжилтийн тайлан мэдээ/
3	Байршил, эдийн засаг нийгмийн хөгжлийн байдал	**Газар зүйн байрлал:** ✓ Баянмөнх сум нь Дорнод Монголын тал хээрийн бүсэд багтаж физик газарзүйн мужлалаар хуурай хээрийн бүсэд хамаарч сумын төв нь Хэрлэн голын сав газарт далайн түвшнээс дээш 1110 орчим метр өндөрт Хойд өргөргийн 46 градус 53 минут 81.1 секунт, Зүүн уртрагийн 109 градус 46 минут 27.1 секунт-д Улаан-Эрэг хэмээх газар байрладаг. Газрын гадаргуугийн налуу 1,0-1,5 градус, далай төвшнөөс дээш 1115-1233 метр өргөгдсөн, газрын гадарга нь ухаа гүвээ, толгод, нам уулс, хотгор бүхий талархаг байдалтай. Нийт 255385 га нутаг дэвсгэртэйгээс хөдөө аж ахуйн газар 252231 га, хадлангийн талбай 7400 га, тариалангийн талбай 151 га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 397 га,/ хот тосгон

		бусад суурины газар 240 га, зам шугам сүлжээний газар 1412 га, усны сан бүхий газар 1501 га, улсын тусгай хэрэгцээний газар 1 га эзэлж байна. Баруун, баруун урд талдаа Дархан сум, баруун хойд талдаа Дэлгэрхаан сум, хойд талдаа Жаргалтхаан сум, зүүн хойд талдаа Мөрөн сум, зүүн талдаа Баянхутаг сум, зүүн урд талдаа Галшар сум, урд талдаа Дорноговь аймгийн Их хэт сумдуудтай тус бүр хиллэдэг. Улсын нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Чингис хотоос 100 км алслагдсан. **Байршил:** ✓ Хэнтий аймгийн Баянмөнх сум Баянбулаг 1-р багийн нутаг Бүрдний эх **Хүн ам, малын тоо** ✓ Баянмөнх сум нийт 1763 хүн амтай. Үүнээс Баянбулаг 1-р баг 135 өрхийн 442 хүн амтай. ✓ Малын тоо: тэмээ 286, адуу 1274, үхэр 1906, хонь 11080, ямаа 11789 нийт 26335 толгой малтай. **Цаг уурын нөхцөл**: ✓ Сумын нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай хоногийн ба жилийн халуун хүйтний хэлбэлзэл ихтэй. Жилийн дөрвөн улиралд унах тунадасны хувиарлалт бага хуурай сэрүүн байдаг. Агаарын температурын олон жилийн дунджаар авч үзэхэд агаарын үнэмлэхүй их температур зуны улиралд +25+28, үнэмлэхүй бага температур өвлийн улиралд -23-28, хур тунадасны жилийн дундаж хэмжээ 70-80 мм, салхины жилийн дундаж хурд 4-8 метр секунт байх ба зонхилох салхины чиглэл баруун өмнө зүгээс байна. **Эдийн Засгийн тэргүүлэх чиглэл** ✓ Хөдөө аж ахуйд суурилсан бөгөөд бэлчээрийн мал аж ахуй **Нийгмийн дэд бүтцийн хөгжил**: ✓ Сумын төвийн голлох барилгууд болох ЗДТГазар, ЕБСургууль, Дотуур байр, ЭМТөв, Соёлын төв, Цэцэрлэг, Ахуй үйлчилгээ, Уурын зуух гэх мэт барилгууд 2020 онд нэгдсэн халаалт цэвэр усны системд холбогдсон. 2022 онд цэвэрлэх байгууламж ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон. ✓ Шилэн кабелийн шугам сүлжээтэй ба үүрэн холбооны Мобиком, Жи мобайл, Скайтел, Юнитель 4 сүлжээнд холбогдсон.

		✓ Байнгын 24 цагийн эрчим хүчний эх үүсвэртэй. Дэд станцтай
4	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ /га/	Баянмөнх сумын Баянбулаг 1-р багийн нутаг Бүрдний эх координат уртраг 109^0 38/ 30.1// өргөрөг 46^0 46/ 02,6//. 70*56 харьцаа бүхий нийт 3920 $м^2$ газар хашаална. Хашааг бүхэлд нь турбагаар хийж гагнана. Хашааны материалын турба нь 60 мм-ээс багагүй диаметртэй байна. Нийт 126 байр хашаа байх ба 1 хашааны урт - 2 м, өндөр нь-1,5 м, хашаа нь 7 хөндлөн холбоостой байх ба холбоос хоорондын зай 20 см-ээс ихгүй байна. Хашааны дээд талын ирмэг битүү аюулгүй байна. Шонгын турба нь 80-мм –ээс багагүй диаметртэй турба байх ба өндөр нь 2 м байна. Газарт 50 см сууж газраас дээш хашаатай чацуу 1,5 м байна. Хашааг шонтой хамт гагнаж холбоно. Хашааны шонг цементээр бөхлөж газарт цутгаж суулгана. Хашаа нь дотор талруугаа налуу байна.
5	Булаг хашихад тавигдах шаардлага	✓ Орон нутгаас ажиллах хүч авч түр ажлын байраар хангах ✓ Иргэдийн болон холбогдох албан тушаалтаны хяналтан дор ажил гүйцэтгэх ✓ Булгийн эх ундаргыг сайтар цэвэрлэх ✓ Хашааны материал хэлбэр хийцийг хүн, малд аюулгүй байдлаар шийдвэрлэх
6	Баримт бичгийн бүрдэл	✓ Ажил гүйцэтгэлийн зураг, санхүүжилтийн тайлан мэдээг хүлээлгэж өгөх ✓ Материалыг тус бүр 2 хувь үйлдэж ЗДТГазрын архивт 1 хувийг, БОБайцаагчид 1 хувийг хүлээлгэн өгнө.
7	Булаг хашсанаар шийдвэрлэх асуудал	✓ Усны ундарга сайжирна. ✓ Булгийг тойрон ургаж буй ашигт ургамал хамгаалагдаж нэр төрөл нь нэмэгдэнэ. ✓ Зэрлэг ан амьтан усаар хангагдана. ✓ Хүрээлэн буй орчны байгалийн тэнцвэрт байдал сайжирна.
8	Ажил гүйцэтгэх хугацаа	✓ 2025 оны 09-р сараас 10-р сарын 20, хуанлын 20 хоногт
9	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Хэнтий аймгийн Баянмөнх сумын ЗДТГазар Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх сангийн хөрөнгө
10	Батлагдсан төсөв	31,500,000 /гучин нэгэн сая таван зуун мянган төгрөг/
11	Захиалагч байгууллага	Баянмөнх сум Засаг Даргын Тамгын газар /РД:9075437/
12	Гүйцэтгэгч байгууллага	ААНэгж, Ашиглагч Малчны бүлэг, иргэд
13	Зөвшилцөх байгууллага	Аймгийн Байгаль орчны газар, сумын Засаг Даргын Тамгын газар

14	Онцгой нөхцөл	Ажил гүйцэтгэх явцад захиалагчтай зөвшилцөх, ажлын явцыг холбогдох мэргэжилтэний хяналтын дор гүйцэтгэх.

Хашааны загвар

Турбаны диаметр-60мм-ээс багагүй байна.



Шонгийн турбаны диаметр-80мм-ээс багагүй байна.

Хашааны тооцоо

№	Материалын нэр төрөл	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ	Техникийн тодорхойлолт
1	Төмөр шонтой төмөр хашаа	байр	250,000	126	31,500,000	Хашааг бүхэлд нь турбагаар хийж гагнана. Хашааны материалын турба нь 60 мм-ээс багагүй диаметртэй байна. Нийт 126 байр хашаа байх ба 1 хашааны урт -2 м, өндөр нь-1,5 м, хашаа нь 7 хөндлөн холбоостой байх ба холбоос хоорондын зай 20 см-ээс ихгүй байна. Хашааны дээд талын ирмэг битүү аюулгүй байна. Шонгын турба нь 80-мм –ээс багагүй диаметртэй турба байх ба өндөр нь 2 м байна. Газарт 50 см сууж газраас дээш хашаатай чацуу 1,5 м байна. Хашааг шонтой хамт гагнаж холбоно. Хашааны шонг цементээр бөхлөж газарт цутгаж суулгана. Хашаа нь дотор талруугаа налуу байна.
	Нийт дүн				**31,500,000**	